

Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргах журам

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1 Засгийн газрын нийтлэг зориулалттай нэгтгэсэн санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн гаргахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн зорилго нь Засгийн газрын хяналтанд байгаа бүх хөрөнгө, эх үүсвэр, өр төлбөрийг багтаасан санхүүгийн байдлыг харуулан иргэд, сонгогчдын өмнө Засгийн газрын хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлтийн талаарх үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүргэхэд оршино.
- 1.3 УСНББОУС 6 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтад байгаа байгууллагын нягтлан бодох бүртгэл” стандартын 15-р зүйлд заасны дагуу Засгийн газрын болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргана.
- 1.4 Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэгтгэлд УСНББОУС-6 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтад байгаа байгууллагын нягтлан бодох бодох бүртгэл” стандартын 20-р зүйлд заасны дагуу хяналтад байгаа бүх байгууллагыг нэгтгэнэ.

Хоёр. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх зарчим

2. Санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмыг баримтлана. Үүнд:
 - 2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа төсөвт байгууллагыг татан буулгах, үйл ажиллагааг зогсоох нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмаар гаргана.
 - 2.2 Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь үзүүлэлтүүдийн толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгална.
 - 2.3 Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай зэрэгцүүлэгдэхүйц зэрэгцүүлэх боломжтой байна.
 - 2.4 Нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг зүйлсийг тусад нь толилуулна. Материаллаг бус дүнтэй зүйлүүдийг шинж чанар буюу үүргийн дагуу ижил зүйлүүдийн дүнтэй нэгтгэн толилуулж болно.
 - 2.5 Энэхүү заавар, аргачлал болон УСНББОУС-аар цэвэр дүнг гаргахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд хөрөнгө ба өр төлбөрийг цэвэр дүнгээр толилуулахгүй.

- 2.6 Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, аргачлал болон УСНББОУС-д өөрөөр зөвшөөрсөн буюу шаардаагүй бол санхүүгийн тайланд тусгагдсан өмнөх ба тайлант үеийн бүх тоон мэдээллийг тодруулна. Тайлант хугацааны санхүүгийн тайланг ойлгомжтой болгохын тулд зэрэгцүүлэгдэх мэдээлэлд хүүрнэсэн ба тайлбарласан мэдээллийг оруулна.
- 2.7 Нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахдаа Сангийн сайдын тушаалаар батлагдсан дансны нэгдсэн жагсаалтыг ашиглана.
- 2.8 Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр /сая төгрөгөөр/ гаргана.

Гурав. Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх үйл явц

- 3.1 Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна.
 - 1) Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мэдэгдэл
 - 2) Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан
 - 3) Нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 - 4) Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
 - 5) Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
 - 6) Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэл, тодруулга
 - 7) Нэмэлт мэдээлэл
 - a. Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан
 - b. Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 - c. Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
 - d. Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 3.2 Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 32 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргана.
- 3.3 Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мэдэгдэлд Монгол Улсын Ерөнхий сайд болон Сангийн сайд гарын үсэг зурж тамга дарна.
- 3.4 Нэгтгэсэн санхүүгийн байдлын, үр дүнгийн, мөнгөн гүйлгээний болон цэвэр хөрөнгө өмчийн тайланд Сангийн сайд, Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга тус тус гарын үсэг зурж тамга дарна.
- 3.5 Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхдээ Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, болон төв төрийн сангийн санхүүгийн тайланг УСНББОУС 6 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтанд байгаа байгууллагын нягтлан бодох бүртгэл” стандартын 39-р зүйлд заасны дагуу хяналтанд байгаа байгууллагын хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардлын зүйл тус бүрийг мөр-мөрөөр нь нэмэх нэгтгэлийн горимын дагуу нэгтгэнэ.
- 3.6 Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахдаа төсвийн ерөнхийлөн захирагчдын болон төрийн сангийн хоорондын тооцооны үлдэгдэл, ажил гүйлгээг бүрэн устгана.

- 3.7 Сангийн сайдын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь сангийн яамны болон харьяа агентлагуудын нэгтгэсэн тайлан түүнчлэн хэрэгжүүлж байгаа төсөл сангийн санхүүгийн тайлангаас бүрдэнэ.
- 3.8 Төв төрийн сангийн санхүүгийн тайланд Сангийн сайдын багцын төсөвт батлагдсан орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн татаас, төсвийн ерөнхийлөн захирагчид олгосон санхүүжилт гэх мэт нийт төсвийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт хамааралтай ажил гүйлгээг тусгана.
- 3.9 3.8-т заагдсан ажил гүйлгээг Сангийн сайдын нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэхгүй болно.

Дөрөв. Санхүүгийн тайланг хүлээн авах

- 4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийг хариуцсан ажилтан эсвэл ерөнхий нягтлан бодогч нь өөрийн төсвийн багцад харьяалах төсөвт байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авна.
- 4.2 Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэл хариуцсан ажилтан нь төсөвт байгууллагын улирал, жилийн тайланг доорхи материалд тулгуурлан шалган хүлээн авна. Үүнд:
- а/ Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг банкны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулсан эсэх;
 - б/ Улс, орон нутгийн төсвөөс болон төсвийн ерөнхийлөн захирагчаас авсан урсгал, хөрөнгө оруулалтын санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүн зэрэг хоорондын тооцооны бүх дүнг тулган баталгаажуулах;
 - в/ Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар журмын дагуу гаргасан эсэх;
 - г/ Батлагдсан маягтаар ирүүлсэн тайлан нь цахим хэлбэрээр ирүүлсэн тайлан болон тайлант оны аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байгаа эсэх;
 - д/ Тайлангийн тоон үзүүлэлтүүд нь тооцооллын алдаагүй эсэх;
 - е/ Үзүүлэлт хоорондын уялдааг хангаж байгаа эсэх;
 - ё/ Өмнөх хугацааны тайлантай уялдаж байгаа эсэх;
 - ж/ Байгууллагын санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан эсэх;
 - з/ Эд хөрөнгийн тооллогын бүртгэл, эд хариуцагчийн тооцоо бодсон актуудыг бүрэн хавсаргасан эсэх;
 - к/ Үндсэн хөрөнгө, материалыг данснаас хасах, шилжүүлэх тухай тушаал шийдвэр, устгалтын акттай эсэх;
 - л/ Нягтлан бодохын хураангуй, дэлгэрэнгүй бүртгэлийн дансны бичилтийг тулган шалгах;
 - м/ өр авлагын үлдэгдлийн жагсаалт, тооцоо нийлсэн акттай эсэх;
 - н/ Санхүүгийн тайлангийн алдааг залруулсан үед “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 8.4,8.5-д заасны дагуу болон УСНББОУС-ын холбогдох заалтын дагуу залруулгыг баталгаажуулан тодруулга тайланд тодруулсан эсэх;
 - о/ байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон бусад холбогдох материал;
- 4.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авахдаа доорхи материалд тулгуурлан шалгана. Үүнд:

а/ Улс, орон нутгийн төсвөөс болон төсвийн ерөнхийлөн захирагчаас авсан урсгал, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр авсан болон буцаан төвлөрүүлсэн хөрөнгө, төв төрийн сан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, зээлийн үлдэгдэл зэрэг хоорондын тооцооны бүх дүнг Төрийн сангийн газар, ЗТХАБЗГазруудын асуудал хариуцсан мэргэжилтэнтэй тооцоо нийлэх;

б/ Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар журмын дагуу гаргасан эсэх;

в/ Батлагдсан маягтаар ирүүлсэн тайлан нь цахим хэлбэрээр ирүүлсэн тайлан болон тайлант оны аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байгаа эсэх;

г/ Тайлангийн тоон үзүүлэлтүүд нь тооцооллын алдаагүй эсэх;

д/ Үзүүлэлт хоорондын уялдааг хангаж байгаа эсэх;

е/ Өмнөх хугацааны тайлантай уялдаж байгаа эсэх;

ё/ Нэгтгэсэн тайланд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан эсэх;

ж/ Бусад холбогдох материал

Тав. Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдалд хүлээх үүрэг

- 5.1 Нэгтгэлд хамрагдсан төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргах үүргийг Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 17.1.10, Нягтлан бодох бүртгэлийн тухайн хуулийн 17.1 дэх заалтын дагуу тухайн байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээнэ.
- 5.2 Аймаг, нийслэл, орон нутгийн төрийн сангийн үйл ажиллагааны санхүүгийн тайланг үнэн зөв гаргах үүргийг орон нутгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч хүлээнэ.
- 5.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэгтгэлийг УСНББОУС-6 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтад байгаа байгууллагын нягтлан бодох бодох бүртгэл” стандартын нэгтгэлийн горимын дагуу нэгтгэх, нэгтгэлд хамрагдах байгууллагыг бүрэн хамруулах үүргийг нэгтгэлийн ажлыг хариуцсан мэргэжилтэн эсвэл ерөнхий нягтлан бодогч хүлээнэ.
- 5.4 Төв төрийн сангийн үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргах үүргийг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга хүлээнэ.
- 5.5 Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэгтгэлийг УСНББОУС-6 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтад байгаа байгууллагын нягтлан бодох бодох бүртгэл” стандартын нэгтгэлийн горимын дагуу нэгтгэх, нэгтгэлд хамрагдах байгууллагыг бүрэн хамруулах үүргийг нэгтгэлийн ажлыг хариуцсан мэргэжилтэн хүлээнэ.